

БАТЛАВ.



АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ
/ МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ /
Дугаар № НТАГ-2019/30

Улаанбаатар хот

Нэг талаас **НТАГ** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **Амгалан ахуй аудит ХХК** (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 12 сарын 13-ны өдөр энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох гэрээгээр аудит хийлгэх тендерийн баримт бичигт тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.

2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.

3. Захиалагч нь Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ № НТАГ-2019/30-г (цаашид “ажил” гэх) 5,000,000.00 /Таван сая/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;

5. Гэрээ нь энд дурдсан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

6. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

7. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдлыг арилгах үүрэг, хариуцлагыг хүлээж байна.

8. Захиалагч нь гэрээний дагуу зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдлыг арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хариуцлага хүлээж байна.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Ц. Бат-Өлзий /Санхүүгийн
аудитын хэлтсийн дарга/

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 8 дугаар
хороо Соёлын төв өргөө, "Г"
корпус, 5 давхар
Утас/факс: 976-11-320154
Харилцагч банк - Төрийн сан,
100200024401

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Б.Цэцэгмаа /Аудитор/

Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Хүннүгийн гудамж,
Тайм тауэр, 218-р байр 154 тоот
Утас/факс: 976-77011044, 88054499
Харилцагч банк: Голумт банк-
1415101282

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Д.Хатанбаатар / Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын захирал /

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, Энх тайван найрамдлын

ордон, 2 давхарт 201 тоот

Утас/факс: 99086371

Харилцагч банк: